

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/32/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Х.Сувдмаа Утас: 70373089 Цахим хаяг: suvdmaakh@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ДАРХАН -УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА,
БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Д.БАТЧУЛУУН ТАНАА

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 84

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар цалингийн зардлын дансанд 9,126.0 мянган төгрөгийн, бараа материалын дансанд 3,602.3 мянган төгрөгийн, өр төлбөрийн дансанд 3,602.3 мянган төгрөгийн зөрчил тус тус илэрч, нийт 16,330.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа нь бидний тогтоосон 10,012.8 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-т "Бүх өр төлбөр", Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Аймаг, нийслэлийн Засаг дарга нь хот байгуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 9.1.3-т "Ерөнхий архитектороор удирдуулсан Хот байгуулалт, барилга захиалагчийн албыг байгуулах" заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4526050253

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас 2025 оны А/273, А/415 дугаар тушаалаар 11,610.1 мянган төгрөгийн тавилга, машин тоног төхөөрөмж шилжүүлэн авч санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Байгууллагын төлөвлөсөн 70,000.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого 3 дахин буюу 190,963.0 мянган төгрөгөөр давсан нь барилгын техник хяналтын ажил нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас 89.0 хувиар, аймгийн Засаг дарга 90.6 хувиар тус тус үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	272,184,817.65	<u>178,187,761.67</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	235,988,457.40	138,926,411.42
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	234,988,457.40	136,674,645.16
33300	Татаас санхүүжилтийн авлага	1,000,000.00	00.00
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	00.00	2,251,766.26
35	БАРАА МАТЕРИАЛ	36,196,360.25	39,261,350.25
354	Хангамжийн материал	35,598,360.25	37,814,350.25
35100	Түүхий эд материал	598,000.00	1,447,000.00
35110	Тусгай зориулалттай материал	598,000.00	1,447,000.00
35410	Бичиг хэргийн материал	6,470,749.00	7,136,639.00
35420	Аж ахуйн материал	18,123,650.00	18,123,650.00
35430	Сэлбэг хэрэгсэл	9,027,044.00	10,053,044.00
35470	Бусад хангамжийн материал	1,976,917.25	2,501,017.25
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>579,190,100.28</u>	<u>558,049,225.08</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	579,190,100.28	558,049,225.08
392	Биет хөрөнгө	347,943,666.74	332,018,391.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	271,513,749.56	271,513,749.56
39202	Хуримтлагдсан элэгдэл	(44,526,146.40)	(51,947,170.68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	56,500,000.00	60,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	(7,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	224,774,969.54	214,248,706.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	(182,112,249.78)	(176,544,156.54)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,364,480.00	28,228,350.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,741,886.50)	(25,275,143.94)
39214	Бусад үндсэн хөрөнгө	32,430,913.84	32,430,913.84
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,260,163.52)	(13,136,857.28)
393	Биет бус хөрөнгө	231,246,433.54	226,030,833.58
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(880,000.00)	(880,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	261,334,000.00	261,334,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(30,087,566.46)	(35,303,166.42)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>851,374,917.93</u>	<u>736,236,986.75</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>851,374,917.93</u>	<u>736,236,986.46</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	414,411,421.92	414,411,421.92
	Өмч - Төрийн өмч	414,411,421.92	414,411,421.92
512	Хуримтлагдсан үр дүн	333,342,200.28	218,204,268.81
51210	Өмнөх үеийн үр дүн	129,630,043.24	333,342,200.28
51220	Тайлант үеийн үр дүн	203,712,157.04	(115,137,931.47)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	103,621,295.73	103,621,295.73
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>851,374,917.93</u>	<u>736,236,986.46</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,180,460,767.65	1,182,353,474.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	261,037,950.40	175,570,374.16
120	Нийтлэг татварын бус орлого	261,037,950.40	175,570,374.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	261,037,950.40	175,570,374.16
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	249,088,150.40	162,649,224.16
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө	11,949,800.00	11,610,150.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал		1,311,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	919,422,817.25	1,006,783,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	793,832,400.00	850,883,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	793,832,400.00	850,883,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	124,539,000.00	155,900,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	124,539,000.00	155,900,000.00
1330	Төсвийн захирагчдаас	1,051,417.25	1,297,491,405.63
133003	Хөрөнгийн	1,051,417.25	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	976,748,610.61	1,297,491,405.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	976,748,610.61	1,297,491,405.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	848,902,148.77	1,044,565,310.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	689,143,146.02	842,831,855.57
210101	Үндсэн цалин	331,007,802.11	435,988,302.73
210102	Нэмэгдэл	282,124,416.70	309,326,265.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,156,549.79	53,880,908.65
210104	Урамшуулал	29,717,795.09	43,636,378.93
210105	Гэрээт ажлын хөлс	136,582.33	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,814,213.47	111,142,108.86
210201	Тэтгэврийн даатгал	68,166,539.19	77,039,279.86
210202	Тэтгэмжийн даатгал	5,987,869.36	8,445,772.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,047,199.33	4,748,090.53
210204	Ажилгүйдлийн даатгал	2,881,734.77	4,304,388.22
210205	Эрүүл мэндийн даатгал	11,730,870.82	16,604,577.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,552,973.47	11,657,128.16
210301	Гэрэл, цахилгаан	3,122,722.53	6,613,100.13
210302	Түлш, халаалт	4,611,322.38	3,786,178.44
210303	Цэвэр, бохир ус	1,818,928.56	1,257,849.59
2104	Хангамж, бараа материалын зардал	12,034,840.00	13,292,054.00
210401	Бичиг хэрэг	7,709,340.00	7,152,960.00
210402	Тээвэр, шатахуун	3,788,120.00	5,755,894.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	236,030.00	231,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	301,350.00	98,200.00

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	54,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	333,400.00	-
210604	Урсгал засвар	333,400.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	634,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	634,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,934,720.00	11,660,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,830,020.00	11,660,150.00
210807	Газрын төлбөр	104,700.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,454,855.81	53,982,013.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,574,501.00	17,345,988.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,880,354.81	36,636,025.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,846,461.84	252,926,095.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,298,800.00	22,969,500.02
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,680,000.00	500,000.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	51,618,800.00	22,469,500.02
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	73,547,661.84	229,956,595.53
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	73,547,661.84	229,956,595.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>203,712,157.04</u>	<u>(115,137,931.47)</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	0.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>203,712,157.04</u>	<u>(115,137,931.47)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,012,168,715.80</u>	<u>1,268,746,136.40</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	93,797,315.80	260,963,036.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93,797,315.80	260,963,036.40
120	Нийтлэг татварын бус орлого	93,797,315.80	260,963,036.40
120041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	93,797,315.80	260,963,036.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	918,371,400.00	1,007,783,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	793,832,400.00	850,883,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	793,832,400.00	850,883,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	124,539,000.00	156,900,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	124,539,000.00	156,900,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>955,668,715.80</u>	<u>1,264,861,136.40</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	955,668,715.80	1,264,861,136.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	826,822,253.96	1,011,935,040.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	689,143,146.02	845,083,621.83
210101	Үндсэн цалин	331,007,802.11	438,240,068.99
210102	Нэмэгдэл	282,124,416.70	309,326,265.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,156,549.79	53,880,908.65
210104	Урамшуулал	29,717,795.09	43,636,378.93
210105	Гэрээт ажлын хөлс	136,582.33	0.00-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,814,213.47	111,142,108.86
210201	Тэтгэврийн даатгал	68,166,539.19	77,039,279.86
210202	Тэтгэмжийн даатгал	5,987,869.36	8,445,772.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,047,199.33	4,748,090.53
210204	Ажилгүйдлийн даатгал	2,881,734.77	4,304,388.22
210205	Эрүүл мэндийн даатгал	11,730,870.82	16,604,577.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,552,973.47	11,657,128.16
210301	Гэрэл, цахилгаан	3,122,722.53	6,613,100.13
210302	Түлш, халаалт	4,611,322.38	3,786,178.44
210303	Цэвэр, бохир ус	1,818,928.56	1,257,849.59
2104	Хангамж, бараа материалын зардал	2,913,140.00	389,419.00
210401	Бичиг хэрэг	385,000.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	1,990,760.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	236,030.00	297,119.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	301,350.00	92,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	333,400.00	0.00
210604	Урсгал засвар	333,400.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	634,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	634,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,934,720.00	11,660,150.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,830,020.00	11,660,150.00
210807	Газрын төлбөр	104,700.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,496,661.00	32,002,613.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,496,661.00	32,002,613.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,846,461.84	252,926,095.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,298,800.00	22,969,500.02
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	51,618,800.00	22,469,500.02
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,680,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	74,547,661.84	229,956,595.53
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	74,547,661.84	229,956,595.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>56,500,000.00</u>	<u>3,885,000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	56,500,000.00	3,885,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	56,500,000.00	3,885,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	56,500,000.00	3,885,000.00
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	56,500,000.00	3,885,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(56,500,000.00)</u>	<u>(3,885,000.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(0.00)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	414,411,421.92	103,621,295.73	129,630,043.24	-	647,662,760.89
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	414,411,421.92	103,621,295.73	129,630,043.24	-	647,662,760.89
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	203,712,157.04	-	203,712,157.04
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	414,411,421.92	103,621,295.73	333,342,200.28	-	851,374,917.93
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	414,411,421.92	103,621,295.73	333,342,200.28	-	851,374,917.93
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	414,411,421.92	103,621,295.73	333,342,200.28	-	851,374,917.93
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(115,137,931.47)	-	(115,137,931.47)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	414,411,421.92	103,621,295.73	218,204,268.81	-	736,236,986.46

2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	929,413,300.00	891,289,114.19	(38,124,185.81)	95.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	899,948,300.00	868,319,614.17	(31,628,685.83)	96.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	856,838,900.00	832,432,001.17	(24,406,898.83)	97.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	726,983,300.00	714,387,204.48	(12,596,095.52)	98.3
210101	Үндсэн цалин	419,952,900.00	438,240,068.99	18,287,168.99	104.4
210102	Нэмэгдэл	174,777,900.00	178,629,847.91	3,851,947.91	102.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	91,930,400.00	53,880,908.65	(38,049,491.35)	58.6
210104	Урамшуулал	40,322,100.00	43,636,378.93	3,314,278.93	108.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,687,100.00	94,338,099.53	(7,349,000.47)	92.8
210201	Тэтгэврийн даатгал	67,595,500.00	64,611,874.99	(2,983,625.01)	95.6
210202	Тэтгэмжийн даатгал	8,522,900.00	7,346,219.22	(1,176,680.78)	86.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,261,400.00	4,136,792.22	(124,607.78)	97.1
210204	Ажилгүйдлийн даатгал	4,261,400.00	3,748,642.66	(512,757.34)	88.0
210205	Эрүүл мэндийн даатгал	17,045,900.00	14,494,570.44	(2,551,329.56)	85.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,106,100.00	11,657,128.16	(1,448,971.84)	88.9
210301	Гэрэл, цахилгаан	4,650,500.00	6,613,100.13	1,962,600.13	142.2
210302	Түлш, халаалт	6,419,600.00	3,786,178.44	(2,633,421.56)	59.0
210303	Цэвэр, бохир ус	2,036,000.00	1,257,849.59	(778,150.41)	61.8
2104	Хангамж, бараа материалын зардал	2,141,600.00	389,419.00	(1,752,181.00)	18.2
210401	Бичиг хэрэг	1,244,800.00	-	(1,244,800.00)	0.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	448,700.00	297,119.00	(151,581.00)	66.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	448,100.00	92,300.00	(355,800.00)	20.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,500.00	0.00	(37,500.00)	0.0
210604	Урсгал засвар	37,500.00	0.00	(37,500.00)	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,883,300.00	11,660,150.00	(1,223,150.00)	90.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,121,700.00	11,660,150.00	(461,550.00)	96.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	322,600.00	0.00	(322,600.00)	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	439,000.00	0.00	(439,000.00)	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,109,400.00	35,887,613.00	(7,221,787.00)	
210902	Бараа үйлчилгээний бусад зардал	43,109,400.00	35,887,613.00	(7,221,787.00)	

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,465,000.00	22,969,500.02	(6,495,499.98)	78.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,465,000.00	22,969,500.02	(6,495,499.98)	78.0
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	28,965,000.00	22,469,500.02	(6,495,499.98)	77.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	929,413,300.00	891,289,114.19	(38,124,185.81)	95.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	929,413,300.00	891,289,114.19	(38,124,185.81)	95.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	859,413,100.00	821,288,914.19	(38,124,185.81)	95.6
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	70,000,200.00	70,000,200.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	24.00	(4.00)	85.7
620001	Удирдах ажилтан	3.00	3.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	16.00	(4.00)	80.0
620004	Үйлчлэх	5.00	5.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Тайлан он
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	147,500,426.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	147,500,426.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	147,500,426.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,696,417.35
210102	Нэмэгдэл	130,696,417.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,804,009.33
210201	Тэтгэврийн даатгал	12,427,404.87
210202	Тэтгэмжийн даатгал	1,099,553.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	611,298.31
210204	Ажилгүйдлийн даатгал	555,745.56
210205	Эрүүл мэндийн даатгал	2,110,007.37
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	147,500,426.68
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	147,500,426.68
131103	ЗГНХ, ЗД-ын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	147,500,426.68
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй 16,330.6 мянган төгрөгийн зөрчил илэрч, бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Аудитаар мөнгөн гүйлгээний тайланд 1,012,168.7 мянган төгрөгийн мөнгөн орлого, зарлагын эхний үлдэгдлийг тусгаагүй орхигдуулсан нь УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" санхүүгийн тайлагналын "Толилуулга" батламж мэдэгдлийг хангаагүй тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасны дагуу мөнгөн гүйлгээний тайлангийн эхний үлдэгдлийг нэмэгдүүлж залруулав.

Мөн аудитаар нийт 16,330.6 мянган төгрөгийн зөрчил¹-д 1,484.0.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 6,835.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 8,011.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд байгууллагын ерөнхий нягтлан бодогч Г.Энхжинд улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 1,484.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

1. Тус газрын бүтэц, орон тоонд аймгийн ерөнхий архитекторын албан тушаал батлагдаагүй байхад С.Дарханбаатарыг томилж, 3,232.8 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Аймаг, нийслэлийн Засаг дарга нь хот байгуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 9.1.3-т "Ерөнхий архитектороор удирдуулсан Хот байгуулалт, барилга захиалагчийн албыг байгуулах", Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2024 оны Б/50 дугаар тушаал, Дархан-Уул аймгийн ГХБХБГ-ын даргын 2025 оны А/01 дүгээр тушаалтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Тус газар нь 2025 оны эхний хагас жилд худалдан авч, зарцуулсан 3,602.3 төгрөгийн шатахууны талоньг бараа материалын дансаар дамжуулалгүй үйл ажиллагааны зардалд бүртгэж, тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-т "Бүх өр төлбөр", Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 8 дугаар зүйлийн 8.3-т "Бараа материалыг УСНББОУС12 "Бараа материалын"-ын дагуу бүртгэнэ", 8.21-т "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн байнгын системийг ашиглан бараа материалыг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

бүртгэнэ” гэж заасантай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлийг хангахгүй байна

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Бараа материалын зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус газрын авто машины замын хуудсыг шалгахад 3,602.3 мянган төгрөгийн жолоочийн тооцооны хуудсанд ирсэн, явсан цаг, маршрут, зарцуулсан шатахуун, явсан хүний албан тушаал, гарын үсэг зурагдаагүй, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргаагүй, спидометрийн заалтыг бичээгүй, шатахууны тооцоог бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, 13.7, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, 13.7, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт “Жолоочийн тооцооны хуудас” дахь заалтад заасан маягтын дагуу гаргаж, жолоочийн замын хуудсанд ирсэн, явсан цаг, спидометрийн заалтыг нэг бүрчлэн бичүүлж, нягтлан бодогч шатахууны тайланг тооцоо бодсон актаар үйлдэж байх

5.3.2 Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд байгууллагын үйлчилгээний ажиллагсад ур чадварын нэмэгдлийг олгохдоо ажлын үр дүнг тодорхой шалгуур үзүүлэлтээр дүгнээгүй, хавтгайруулан олгосон

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаалын хавсралт 4-т заасны дагуу үйлчилгээний ажиллагсдын ажлын үр дүнг тодорхой шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэх, санхүүгийн тайлагналын “Иж бүрэн байх”, “Үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаалын хавсралт 4-т заасны дагуу үйлчилгээний ажиллагсдын ажлын үр дүнг тодорхой шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд 1,012,168.7 мянган төгрөгийн орлого, зарлагын эхний үлдэгдлийг тусгаагүй орхигдуулсан	1	1,012,168.7	-	1,012,168.7	-	-	1	1,012,168.7	-	-	-	-
Дүн	1	1,012,168.7	1	1,012,168.7	-	-	1	1,012,168.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ерөнхий нягтлан бодогч Г.Энхжинд улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 1,484.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан	1	1,484.0	1	1,484.0	-	-	-	-	-	-	-	-
Байгууллагын үйлчилгээний ажиллагсад ур чадварын нэмэгдлийг олгоходоо ажлын үр дүнг тодорхой шалгуур үзүүлэлтээр дүгнээгүй, хавтгайруулан олгосон.	1	4,409.2	-	-	-	-	1	4,409.2	-	-	-	-
Бүтэц, орон тоонд аймгийн ерөнхий архитекторын албан тушаал батлагдаагүй байхад С.Дарханбаатарыг	1	3,232.8	-	-	1	3,232.8	-	-	-	-	-	-

томилж, 3,232.8 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна													
Шатахууны зардлыг анхан шатны баримтад үндэслээгүй, шатахууны тооцоог бодоогүй, талоныг бараа материалын дансаар дамжуулаагүй зардалд бүртгэж, тайлагнасан байна	1	3,602.3	-	-	1	3,602.3	-	-	-	-	-	-	-
Тайланд тусгасан өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	3,602.3	-	-	-	-	1	3,602.3	-	-	-	-	-
Дүн	1	16,330.6	1	1,484.0	2	6,835.1	2	8,011.5	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан 217,946.9 мянган төгрөгийн 8 гүйлгээ мэдээлээгүй	-	-	-	-	1	621,743.2	-	-
Дүн	-	-	-	-	1	621,743.2	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тус байгууллага нь төрийн өмчид бүртгэлтэй 35-39 ДАВ авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаарыг хэрэглээгүй байна	-	-	-	-	-	-	1	-
Дүн	-	-	-	-	-	-	1	-
Нийт дүн	-	-	-	-	1	621,743.2	1	-